



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Хотонт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын хураангуй тайлан

Аудитын код: АРА-2023/10-НА-СТА-ТТЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn Архангай аймаг 2023 он</p>	<p>Дарга, Тэргүүлэх аудитор Т.Байгалмаа Утас: 7033-3141 Цахим хаяг: Baigalmaat@audit.gov.mn Аудитын менежер Д.Нэргүйбаатар Утас: 7033-2860 Цахим хаяг: Nerguibaatard@audit.gov.mn Аудитор В.Цогжаргал Цахим хаяг: Tsojargalb@audit.gov.mn</p>
--	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ

		ХОТОНТ СУМЫН ЗАСАГ ДАРГА Д.БАТБААТАР ТАНАА
АРХАНГАЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР		
65130 Цэцэрлэг, Архангай аймаг Утас/Факс:976-70333141 И-мэйл: arkhangai@audit.gov.mn		
2023.03.24	№ 145	
танай _____	-ны № _____	-т _____
Хязгаарлалттай дүгнэлт		
<p>Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.3-д заасны дагуу Архангай аймгийн Хотонт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.</p> <p>Хотонт сумын Засаг даргын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.</p> <p style="text-align: center;">Дүгнэлтийн үндэслэл</p> <p>Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.</p> <p>Сумын төсвийн орлогын төлөвлөгөө гүйцэтгэлээр 7 нэр төрлийн 231,388.5 мянган төгрөгөөр тасарсанаас шалтгаалан нийт орлого 172,207.8 мянган төгрөгөөр тасарсан байна.</p> <p>Энэ нь төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалттай нийцэхгүй, зөрчлийн дүн бидний тооцсон материаллагийн хэмжээнээс хэтэрсэн, аудитын тохиолдсон байх, иж бүрэн байх, үнэлгээ ба хуваарилалт, нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.</p> <p style="text-align: center;">Асуудлыг онцолсон хэсэг</p> <p>Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль шинэчлэгдэн, мөрдөгдсөнтэй холбоотой Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлд орсон нэмэлт, өөрчлөлтийн дагуу үл хөдлөх эд хөрөнгийн албан татвар, газрын төлбөр, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогод ногдуулсан хувь хүний орлогын албан татварын орлогууд сумын төсвийн орлогод нэмэгдэж төвлөрсөн.</p>		

Бусад асуудлын хэсэг

Сумын засаг дарга нь 2022 оны жилийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилтын хүрээнд 129 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөж, дэвшүүлсэн зорилт, төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийг аймгийн Засаг даргын тамгын газрын хяналт шинжилгээ, үнэлгээний хэлтсээс 82.1 хувьтай үнэлсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй ба үүнд ямар нэг төрлийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Т.БАЙГАЛМАА

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	766,158.7	580,410.9
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	74,965.6	121,448.3
33	АВЛАГА	429,321.6	415,357.3
35	БАРАА МАТЕРИАЛ	246,871.4	43,605.3
36	НӨӨЦИЙН БАРАА	15,000.0	0.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,541,882.2	2,178,854.6
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,541,882.2	2,178,854.6
39200	Биет хөрөнгө	6,395,134.2	2,138,844.6
39300	Биет бус хөрөнгө	146,748.0	40,010.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,308,040.9	2,759,265.5
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,308,040.9	2,759,265.5
51	Засгийн газрын хувь оролцоо	7,308,040.9	2,759,265.5
51100	Засгийн газрын оруулсан капитал	3,113,349.7	545,657.5
511002	Орон нутгийн төсвийн оруулсан хөрөнгө	3,113,349.7	545,657.5
51200	Хуримтлагдсан үр дүн	2,504,151.2	1,340,275.6
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	1,690,540.0	873,332.5
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,308,040.9	2,759,265.5

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,614,379.0	1,151,819.9
11	ТАТВАРЫН ОРЛОГО	330,920.6	533,857.8
110	Орлогын албан татвар	95,072.7	268,914.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	95,072.7	268,914.2
113	Хөрөнгийн албан татвар	103,103.2	54,361.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	132,744.7	210,582.5
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,965,611.2	114,704.5
120	Нийтлэг татварын бус орлого	1,965,611.2	114,704.5
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,317,847.2	503,257.6
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	5,109,048.2	983,051.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,917,381.4	983,051.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,937,446.5	933,690.9
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,314,583.8	430,726.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	308,601.6	53,615.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,139.2	147,868.5
2104	Хангамж, бараа материалын зардал	126,750.1	48,202.7
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	20,120.9	12,561.4
2107	Томилолт, зочны зардал	4,433.0	2,950.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	19,004.1	14,408.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	429,285.6	223,358.2
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	979,934.8	49,360.3
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	191,666.8	0.0

Архангай аймгийн Хотонт сумын ТТЗ-ийн 2022 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	1,505,330.8	168,768.7
V	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	97,085.8	4,634,097.7
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	1,408,245.0	-4,465,329.0

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр/

Код:	Тайлангийн үзүүлэлт	2021 оны 12-р сарын 31	2022 оны 12-р сарын 31
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	4,655,076.8	1,185,248.8
11	ТАТВАРЫН ОРЛОГО	330,920.6	533,737.8
110	Орлогын албан татвар	95,072.7	268,914.2
1100	Хувь хүний орлогын албан татвар	95,072.7	268,914.2
113	Хөрөнгийн албан татвар	103,103.2	54,241.2
118	Бусад татвар, төлбөр, хураамж	132,744.7	210,582.5
1180	Бусад нийтлэг төлбөр, хураамж	10,394.4	10,798.4
1181	Газрын төлбөр	100,531.2	173,678.6
1182	Байгалийн нөөц ашигласны төлбөр	21,819.2	26,105.6
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	89,695.3	148,253.4
120	Нийтлэг татварын бус орлого	89,695.3	148,253.4
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	4,234,460.9	503,257.6
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,344,139.7	816,514.1
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,344,139.7	816,514.1
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,364,830.6	767,153.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	2,314,583.8	430,696.5
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	308,601.6	53,645.6
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	123,982.8	147,868.5
2104	Хангамж, бараа материалын зардал	127,469.4	44,362.9
2105	Нормативт зардал	317,398.8	0.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	19,364.9	12,069.3
2107	Томилолт, зочны зардал	4,433.0	2,950.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	22,463.5	14,408.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	126,532.8	61,153.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	979,309.1	49,360.3
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	310,937.2	368,734.7
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	242,597.1	167,252.1
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	242,597.1	167,252.1
2200	Дотоод эх үүсвэрээр	242,597.1	167,252.1
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-242,597.1	-167,252.1
VII	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ДҮН	-40,000.0	-155,000.0
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	40,000.0	155,000.0
VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	28,340.0	46,482.6
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	46,625.6	74,965.6
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	74,965.6	121,448.3

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код:	Тайлангийн үзүүлэлт	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн	Нийт цэвэр хөрөнгө/өмч
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	5,899,795.9	5,899,795.9
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	61,180.0	61,180.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	5,960,975.9	5,960,975.9
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	-61,180.0	-61,180.0
9	Тайлант үеийн үр дүн	1,408,245.0	1,408,245.0
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	7,308,040.9	7,308,040.9
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	7,308,040.9	7,308,040.9
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-83,446.3	-83,446.3
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	7,224,594.6	7,224,594.6
19	Тайлант үеийн үр дүн	-4,465,329.0	-4,465,329.0
20	2022 оны 12-р сарын 31-наарх үлдэгдэл	2,759,265.5	2,759,265.5

2.4 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/ мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,603,344.70	1,131,618.50	471,726.20	70.58
21	УРСГАЛ ЗАРДАЛ	825,232.80	809,366.40	15,866.40	98.08
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	780,560.00	764,693.60	15,866.40	97.97
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	437,646.30	430,696.50	6,949.80	98.41
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,706.00	53,645.60	1,060.40	98.06
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	147,870.50	147,868.50	2.00	100.00
2104	Хангамж, бараа материалын зардал	43,778.90	43,778.40	0.50	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	12,069.30	12,069.30	0.00	100.00
2107	Томилт, зочны зардал	2,950.00	2,950.00	0.00	100.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,686.00	12,832.40	7,853.60	62.03
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	60,853.00	60,853.00	0.00	100.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	44,672.80	44,672.80	0.00	100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	44,672.80	44,672.80	0.00	100.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	525,951.90	167,252.10	358,699.80	31.80
23	ЭРГЭЖ ТӨЛӨГДӨХ ТӨЛБӨРИЙГ ХАССАН ЦЭВЭР ЗЭЭЛ	252,160.00	155,000.00	97,160.00	61.47
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,603,344.70	1,168,710.20	434,634.50	72.89
32	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,223,193.40	1,036,907.10	186,286.30	84.77
35	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	380,151.30	131,803.10	248,348.20	34.67
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	52,606.10	-52,606.10	0.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	89,697.80	-89,697.80	0.00
6	ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	158	150		
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	2	2		
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	78	74		

65	ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ	78	74		
----	---------------------	----	----	--	--

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон

/мянган төгрөгөөр /

Код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,460.2
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,460.2
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,460.2
2104	Хангамж, бараа материалын зардал	584.6
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	1,575.6
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	300.0
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,460.2
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	2,460.2

3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар санхүүгийн тайланд залруулга хийгдээгүй. Аудитаар залруулагдаагүй нийт **297,101.1** мянган төгрөгийн зөрчил¹ илэрч зөрчлийг арилгуулах 2 албан шаардлага хүргүүлээ.

3.1 Албан шаардлага

3.1.1 Сумын төсвийн орлого 7 нэр төрөлд 231,388.5 мянган төгрөгөөр тасарсан нь төсвийн орлогын гүйцэтгэл 172,207.8 мянган төгрөгөөр буюу 23.8%-аар тасрахад нөлөөлсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 41.2.1 “Хуулийн дагуу улс, орон нутгийн төсөвт оруулах болон тухайн төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг бүрэн төвлөрүүлэх” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.2 Хоршоо хөгжүүлэх санд 62 зээлдэгчтэй холбоотой 65,712.6 мянган төгрөгийн хугацаа хэтэрсэн зээлийн үлдэгдэлтэй байна.

Энэ нь Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн сайдын тушаалаар баталсан “Хоршоог хөгжүүлэх сангаас хөнгөлөлттэй зээл олгох, сонгон шалгаруулах, эргэн төлүүлэх, хяналт тавих журам”-ын 3 дугаар зүйлийн 3.4.11-т “Сангаас олгосон зээлийн эргэн төлөлтийн төлбөрийг зээлдэгч төлөхгүй тохиолдолд сумын Засаг дарга уг төлбөрийг төлүүлэх арга хэмжээг авч зээлийн дансанд төвлөрүүлнэ”, 11 зүйлийн 11.3-т “Энэ журмыг зөрчсөн гэм буруутай этгээд санд учирсан хохирлыг холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцан барагдуулна.” гэсэн заалтыг зөрчиж байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчлийг арилгуулах, таслан зогсоох албан шаардлага хүргүүлэх

3.1.3 Хотонт сумын засаг дарга нь тайлант хугацаанд шилэн дансанд оруулбал зохих 124 мэдээллээс 110 мэдээллийг хугацаанд нь байршуулсан бол 14 мэдээллийг хугацаа хоцроон байршуулсан байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т “Тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх”, 6 дугаар зүйлийн 6.4.8-т “... төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэрийг 7 хоногийн дотор мэдээлнэ.”, 7 дугаар зүйлийн 7.1.1-т “...төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага, худалдан авах үйл ажиллагаатай холбоотой аливаа шийдвэр гаргасан, гарын үсэг зурсан эрх бүхий албан тушаалтан шилэн дансны мэдээллийг иргэд олон нийтэд хүргэх үүргийг хүлээнэ” гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Зөрчил арилгуулах, давтан гаргахгүй байх албан шаардлага хүргүүлээ.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Хотонт сумын ТТЗ	2	297,101.1	0	0	2	297,101.1	0	0	0	0	0	0

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Байгууллагын нэр	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Хотонт сумын ТТЗ	1	0	0	0	1	0	0	0